

**“ХАСБАНК”-НЫ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН
ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН**
(2023 оны 6-р сарын 30-ний байдлаар)



1. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

ХасБанк нь үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу олон нийтэд шинээр санал болгож буй 52,700,000 ширхэг энгийн хувьцааг амжилттай арилжаалж, 35,667,900,000 төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлсэн болно. Энэхүү санхүүжилтээс шинээр үнэт цаас гаргахтай холбогдон гарсан 1,628,905,180 төгрөгийг шууд зардлуудыг холбогдох журам, СТОУС-ийн дагуу хасаж, үлдсэн хөрөнгийг Банкны зээл, санхүүгийн түрээсийн багцыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардалд:

- Райнос Инвестмент ҮЦК ХХК болон Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК-д төлөх андеррайтерийн шимтгэл;
- Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1-р заалтын дагуу БДО Аудит ХХК-р гүйцэтгүүлсэн бизнесийн үнэлгээний төлбөр;
- Үнэт цаасны бүртгэлийн журмын 3.1.4-р заалтын дагуу Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-р гүйцэтгүүлсэн аудиторын тодорхойлох захидал, дүгнэлтийн төлбөр;
- Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1 заалтын дагуу Өмгөөллийн “Батбаяр энд Партнерс” ХХН-өөр гүйцэтгүүлсэн хуулийн дүгнэлтийн төлбөр;
- МХБ-ийн бүртгэлийн болон анхдагч зэх зээлийн хураамж;
- ҮЦТХТ-ийн бүртгэлийн болон анхдагч зах зээлийн хураамж;
- Бусад зохицуулагч байгууллагуудын шимтгэл.

Үнэт цаас гаргахтай холбоотой дээр дурдсан шууд зардлыг хассаны дараах цэвэр татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн 34,038,994,820 төгрөг болно.

2. Цэвэр санхүүжилтийн зарцуулалтын хэрэгжилт

Зээлийн сегмент	Цэвэр санхүүжилтийг зарцуулах хувь	Цэвэр санхүүжилтийг зарцуулах дүн	2023 оны 6 сарын 30-ний байдлаарх зарцуулалт*
Иргэдийн зээлийн багц	66%	22,465,736,581	17,836,323,782
Байгууллагын зээлийн багц	19%	6,467,409,016	410,959
Санхүүгийн түрээсийн багц	15%	5,105,849,223	2,738,483,452
Нийт	100%	34,038,994,820	20,575,218,193

* Зээл, санхүүгийн түрээсийн үлдэгдэл дүнгээр

Цэвэр санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдэл 13,463,776,627 төгрөг байна.